



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эко баяновоо хот тохижилт” ОНӨААТҮГ-ын 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/012/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Даланзадгад хот 2026 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Ахлах аудитор: Г.Шижирболд Утас: 70533552 Цахим хаяг: shijirboldg@audit.gov.mn Аудитор: О.Чойдорж Утас: 70533552 Цахим хаяг: choidorjo@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

## Агуулга

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	8
3.1 Албан шаардлага .....	8
3.2 Зөвлөмж.....	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	9
Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	10
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	11

# 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,  
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083  
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn  
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.03.16 № 307  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭКО БАЯНОВОО ХОТ ТОХИЖИЛТ  
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА  
М.МӨНХДЭМБЭРЭЛ ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Эко баяновоо хот тохижилт" ОНӨААТҮГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар 2025 оны бизнес төлөвлөгөө батлагдаагүй байхад байгууллагын даргын тушаалаар албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлэн олгосон 1,644.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4 дэх заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Говийн оюу хөгжлийг дэмжих сангийн хөрөнгө оруулалтаар 60,000.0 мянган төгрөгийн хөрөнгө ашиглалтад хүлээлгэн өгсөн байна.

### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид

4278.00.05  
F:\2 Бичиг хэргийн 2026\эцСТА-н дүгнэлт\Төсөл.Docx

тусад нь дүгнэлт гаргахгүй. Тайлант онд 8,469.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

#### **Бусад асуудлын хэсэг**

Аймгийн хэмжээнд хэрэгжүүлж буй нутгийн дэм хөтөлбөрт хамрагдан албан хаагчдад 24,453.5 мянган төгрөг олгосон байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ӨСӨХБАЯР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Д/Д	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	3,418,304.29	208,380.35
2	Дансны авлага	3,675,243.00	20,846,965.48
3	Бараа материал		
4	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	97,942.74	12,390.22
5	Эргэлтийн хөрөнгийн дүн	7,191,490.03	21,067,736.05
6	Үндсэн хөрөнгө барилга	304,845,011.85	323,861,197.81
7	Биет бус хөрөнгө	950,000.00	770,000
8	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	305,795,011.85	324,631,197.81
9	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>312,986,501.88</b>	<b>345,698,933.86</b>
10	Татварын өр	253,192.77	5,479,738.55
11	НДШ-ийн өглөг	-	966,362.98
12	Богино хугацаат өр төлбөрийн дүн	253,192.77	5,479,738.55
13	Бусад урт хугацаат өглөг	305,246,690.85	324,262,876.81
14	Урт хугацаат өр төлбөрийн дүн	305,246,690.85	324,262,876.81
15	Өр төлбөрийн нийт дүн	305,499,883.62	329,742,615.36
16	Эздийн өмч	-	-
17	Өмч: а) төрийн	16,000.00	16,000.00
18	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	7,470,618.26	15,940,318.50
19	Эздийн өмчийн дүн	7,486,618.26	15,956,318.50
20	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>312,986,501.88</b>	<b>345,698,933.86</b>

### 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

(Төгрөгөөр)

Д/Д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Борлуулалтын орлого ( цэвэр )	106,914,607.51	278,697,833.70
2	Борлуулалтын өртөг	95,216,622.43	249,290,941.55
3	Нийт ашиг	11,697,985.08	29,406,892.15
4	Бусад орлого	0	23,294,153.00
5	Ерөнхий ба удирдлагын зардал	8,862,160.70	44,145,792.39
6	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,835,824.38	8,555,252.76
7	Орлогын татварын зардал	28,358.24	85,552.52
8	Татвар дараах ашиг (алдагдал)	2,807,466.14	8,469,700.24
9	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	2,807,466.14	8,469,700.24

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Мөнгөн орлогын дүн (+)	73,045,025.26	236,192,650.83
2	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		
3	Бусад мөнгөн орлого	73,045,025.26	236,192,650.83
4	Мөнгөн зарлагын дүн (-)	71,646,285.91	239,402,574.77
5	Ажиллагчдад төлсөн	28,254,475.00	132,120,434.00
6	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	7,606,488.77	38,540,618.32
7	Бараа материалын худалдан авахад төлсөн	28,989,035.06	41,802,225.17
8	Ашиглалтын зардалд төлсөн		
9	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
10	Татварын байгууллагад төлсөн	6,346,287.08	26,939,297.28
11	Даатгалын төлбөрт төлсөн		
12	Бусад мөнгөн зарлага	450,000.00	
13	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,398,739.35	-3,209,923.94
14	Мөнгөн зарлагын дүн (-)		
15	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
16	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
17	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,398,739.35	-3,209,923.94
18	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,019,564.94	3,418,304.29
19	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,418,304.00	208,380.35

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
20.. оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	16,000.00		7,470,618.26	7,486,618.26
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө алдааны залруулга				
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/			8,469,700.24	8,469,700.24
Бусад дэлгэрэнгүй орлого				
Өмчид гарсан өөрчлөлт				
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				
20.. оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	16,000.00		15,940,318.50	15,956,318.50

## 2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

Үзүүлэлт	2025 оны зорилтот түвшний		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>Нийт орлого</b>	<b>282,754,456.00</b>	<b>301,991,986.7</b>	<b>-19,237,530.70</b>	<b>106.8</b>
Цэвэр бохир усны мөнгөн орлого	42,918,173.00	59,094,754.07	-16,176,581.07	137.7
Бусад орлого /хог/	13,526,478.00	32,059,525.15	-18,533,047.15	237.0
Зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээний орлого	72,703,905.00	66,083,746.67	6,620,158.33	90.9
Хог хаягдлын ачилт, цэвэрлэгээ үйлчилгээний гүйцэтгэлийн орлого	83,363,386.00	69,136,578.80	14,226,807.20	82.9
Нутгийн дэм	28,575,000.00	24,453,568.00	4,121,432.00	85.6
Үнэ төлбөргүй орсон үндсэн хөрөнгийн орлого /элэгдэл/	41,667,514.00	51,163,814.04	-9,496,300.04	122.8
<b>Нийт зардал</b>	<b>281,530,229.00</b>	<b>293,436,734.00</b>	<b>-11,906,505.00</b>	<b>104.2</b>
Цалин	162,899,159.00	162,700,662.80	198,496.20	99.9
НДШ-н зардал	46,533,556.00	39,506,981.30	7,026,574.70	84.9
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	41,667,514.00	41,163,814.04	503,699.96	98.8
Шатахууны зардал	6,000,000.00	6,996,978.60	-996,978.60	116.6
Хөдөлмөр хамгаалал	13,000,000.00	12,845,917.43	154,082.57	98.8
Цахилгааны зардал	4,850,000.00	3,483,128.99	1,366,871.01	71.8
Томилолт	850,000.00	2,440,000.00	-1,590,000.00	287.1
Бичиг хэргийн зардал	600,000.00	645,754.00	-45,754.00	107.6
Сэлбэг засвар үйлчилгээний зардал	3,400,000.00	7,501,304.00	-4,101,304.00	220.6
Бусад зардал	600,000.00	600,000.00	0.00	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж бусад татвар	1,130,000.00	15,552,192.84	-14,422,192.84	1376.3
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг</b>	<b>1,224,227.00</b>	<b>8,555,252.8</b>		
<b>Орлогын татвар хураамж</b>	<b>122,422.7</b>	<b>85,552.5</b>		
<b>Цэвэр ашиг</b>	<b>1,101,804.3</b>	<b>8,469,700.2</b>		

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,453.6 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 24,453.6 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Орлогын дэлгэрэнгүй тайланд нутгийн дэм хөтөлбөрийн санхүүжилт 24,453.6 төгрөгийг бусад орлогоор тусгаагүй тайлагнасан

Аудитаар нийт 1,644.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 1,644.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 1 зөвлөмж өгсөн.

#### 3.1 Албан шаардлага

1. Байгууллагын 2025 оны бизнес төлөвлөгөө батлагдаагүй байхад даргын тушаалаар албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлэн нийт 1,644.0 мянган төгрөгийн илүү цалин олгосон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 4-т *"үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох;"* гэж заасантай нийцэхгүй байна.

#### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжтой холбоотой асуудал

**Илрүүлэлт:**<sup>1</sup> Цалин хөлс тооцож олгохдоо Сангийн сайдын 2017 оны А/347 дугаар тушаалаар баталсан ЦХ-5б маягтыг хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т *"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"*, Сангийн сайдын 2017 оны А/347 дугаар тушаалын хавсралтаар баталсан *"Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"*-ын Дөрөв-т *"Хөдөлмөр цалин хөлсний маягтыг нөхөх заавар"*-ыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Сангийн сайдын 2017 оны А/347 дугаар тушаалаар баталсан Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврын дагуу анхан шатны баримт ажил гүйлгээг бүрдүүлж ажиллах"

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогын дэлгэрэнгүй тайланд нутгийн дэм хөтөлбөрийн санхүүжилт 24,453.6 төгрөгийг бусад орлогоор тусгаагүй тайлагнасан	1	24,453.6			1	24,453.6	1	24,453.6				
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>24,453.6</b>			<b>1</b>	<b>24,453.6</b>	<b>1</b>	<b>24,453.6</b>				

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын 2025 оны бизнес төлөвлөгөө батлагдаагүй байхад даргын тушаалаар албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлэн нийт 1,644.0 мянган төгрөгийн илүү цалин олгосон	1	1,644.0			1	1,644.0						
Цалин хөлс тооцож олгохдоо Сангийн сайдын 2017 оны А/347 дугаар тушаалаар баталсан ЦХ-56 маягтаар хөтлөөгүй	1	-					1	-				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>1,644.0</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>1,644.0</b>	<b>1</b>	<b>-</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								